



БАЯНХОНГОР АЙМАГ
ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 21 өдөр

Дугаар А/15

Эмзэлтөлгой

Өвөл, хаврын хурдан морины
уралдааныг хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, Засгийн газрын 2019 оны “Хурдан морины уралдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 57 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2019 оны “Өвөл, хаврын хурдан морины уралдааныг хориглох тухай” А/79 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Аймгийн Хууль, эрх зүйн хэлтсийн даргын 2022 оны 4/255 дугаар албан бичиг, аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Улсын байцаагчын 01 дүгээр зөвлөмжийн хүрээнд хурдан морины унаач хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор сумын хэмжээнд 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээ зохион байгуулахыг хориглосугай.

2. Нийт эцэг, эхчүүдэд хүүхдүүдээ тавих хараа хяналтаа сайжруулахыг зөвлөж, хурдан морины уралдааны үед гарч болох болзошгүй осол гэмтэл, сөрөг нөлөө, үр дагаврыг иргэд, олон нийтэд ухуулан таниулж ажиллахыг Ерөнхий боловсролын сургуулийн Нийгмийн ажилтан, анги удирдсан багш нарт тус тус даалгасугай.

3. Нутаг дэвсгэрийн хэмжээнд хурдан морины уралдаан зохион байгуулахгүй байхад хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн тасаг, Хэсгийн төлөөлөгч (Дэслэгч Б.Амарзаяа)-д үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Өнөрбаяр)-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХЖАРГАЛ

